



# ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

09.07 - 09.11



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**АНУ:** Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд бууралттай хаагдлаа. Технологийн компаниудыг илүүтэйгээр агуулдаг Nasdaq Composite индекс 9-р сарын 2-ны түүхэн дээд түвшнээсээ 10%-аас их буюу "correction" бүсэд хүрч хаагдсан бол S&P 500 индексэд мөн технологийн салбар хамгийн их бууралттай байлаа. Мөн Саудын Арабаас зарим харилцагчдаа газрын тосыг хямдралтай худалдаж байгаатай холбоотой АНУ-д газрын тосны үнэ 7-р сараас хойш нэг баррель нь 40 ам.доллараас бага үнэтэй болсноор эрчим хүчний салбар бууралттай байлаа. Харин бараа материалын салбар болон үйлдвэрлэлийн салбар хамгийн их өсөлттэй байлаа. Хөдөлмөрийн өдрийг тохиолдуулан Даваа гарагт АНУ-ын зах зээл хаалттай байлаа.

**Европ:** Европын төв банк эдийн засгийг дэмжих нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэхгүй болсон болон хэлэлцээргүй Brexit болох айдас дахин сэргэсэн ч эдийн засгийн сэргэлт үргэлжилж байгаатай холбоотой Еуропын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Европын хөрөнгийн зах зээлийн бүхэлд нь агуулах STOXX Europe 600 индекс 1.67%-аар өссөн бол Xetra DAX индекс 2.80%-аар, CAC 40 индекс 1.39%-аар, FTSE MIB индекс 2.21%-аар өссөн бол FTSE 100 индекс Их Британийн фунтын ханш суларсантай холбоотой 4.02%-аар өссөн байна. Их Британийн FTSE индексийн сагсанд багтах ихэнх компаниуд бусад улсуудаас ихээхэн хэмжээний орлогоо олдог үндэстэн дамнасан компаниуд байдаг тул Их Британийн фунтын ханш сулрахад тус компаниудын хувьцааны ханш өссөн байна.

**Япон:** Зах зээлийн савлагаа ихтэй байсан энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Nikkei 225 индекс 201 нэгжээр буюу 0.87%-аар өсөж 23,406.49 нэгж дээр хаагдсан нь оны эхэн үеэс 1.1%-аар бууралттай байна. Япон улсын хувьцааны зах зээлийг бүхэлд нь илтгэдэг TOPIX индексүүд мөн адил өсөлттэй хаагдсан байна. Иений ам.долларын эсрэг ханш энэ долоо хоногт харьцангуй тогтвортой байсан ба Баасан гарагийн байдлаар 1 ам.доллар 106 иентэй тэнцэж байна.

The Asahi Shimbun сонинд Ёшихидэ Суга 9-р сарын 14-нд болох Либерал Ардчилсан Намын Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөгч Батлан хамгаалахын сайд асан Шигеру Ишиба, Гадаад хэргийн сайд асан Фумио Кишида нарыг илт давуу байдлаар ялахаар байна гэж нийтэлжээ. Ерөнхий сайд Шинзо Абэгийн оронд томилогдох хүнийг 9-р сарын 16-ны өдрийн ээлжит бус чуулганаар сонгоно.

**БНХАУ:** БНХАУ-ын А төрлийн хувьцаанууд ойролцоогоор 3%-аар буурсан байна. АНУ-ын технологийн компаниудын уналт болон АНУ-ын эрх баригчдаас АНУ-аас хориг тавьсан компаниудын жагсаалтад БНХАУ-ын хамгийн том чип үйлдвэрлэгч компани болох Хагас дамжуулагч үйлдвэрлэлийн олон улсын корпорацыг (SMIC) нэмэх асуудлыг хэлэлцэж байгаа гэсэн мэдээ нь БНХАУ-ын хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлжээ. SMIC нь дотоодын зах зээлд хагас дамжуулагчийн гол нийлүүлэгч ба БНХАУ-ын эрх баригчид болон батлан хамгаалах салбартай нягт холбоотой байдгаас үүдэн БНХАУ-ын олон технологийн компаниудын хувьцаа уналтад оржээ.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,898.25	-0.54% ▼
Dow Jones	АНУ	27,665.64	-1.66% ▼
S&P 500	АНУ	3,340.97	-2.51% ▼
Nasdaq	АНУ	10,853.55	-4.06% ▼
S&P/TSX	Канад	16,222.46	0.03% ▲
FTSE 100	Их Британи	6,032.09	4.02% ▲
S&P/ASX 200	Австрали	5,859.40	-1.12% ▼
Nikkei 225	Япон	23,406.49	0.87% ▲
Hang Seng	Хонг Конг	24,503.31	-0.78% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.88
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	103.46
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.36
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	103.91
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	101.15
DBM' 2023	USD	7.250%	105.44
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	98.07

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.152	-0.01 ▼
Libor 3M	0.250	0.01 ▲
Libor 6M	0.282	-0.04 ▼
Libor 1YR	0.414	-0.02 ▼
US 2YR Bond	0.129	-0.10 ▼
US 3YR Bond	0.149	-0.14 ▼
US 5YR Bond	0.248	-0.17 ▼
US 10YR Bond	0.661	-0.08 ▼

Валютын ханш	2020.09.11	Өөрчлөлт
USD	2,854.77	0.05% ▲
CNY	417.56	0.10% ▲
EUR	3,378.48	0.00% ▲
RUB	38.11	0.34% ▲
KRW	2.41	0.42% ▲
JPY	26.87	-0.04% ▼
CAD	2,167.47	-0.43% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,940.55	0.34% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	26.73	-0.67% ▼
Зэс	USD/lb.	303.95	-0.73% ▼
Нүүрс	USD/MT	55.00	6.80% ▲
WTI газрын тос	USD/bbl.	37.33	-6.14% ▼
Brent газрын тос	USD/bbl.	39.83	-6.63% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.27	-12.36% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.VII	3.40%
Бодлогын хүү	2020.VII	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.VII	8.85%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.VII	10.91%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.VII	4.24%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.VII	16.89%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.VII	10.45%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 49 компанийн 372.6 сая төгрөгийн 2,344,075 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Материалимпекс” /MSE: MIE/ компанийн хувьцаа 17.98%-аар буюу хамгийн ихээр өсөж 8,265.00 төгрөг хүрч хаагдсан бол “Э-транс ложистикс” /MSE: ETR/ компанийн хувьцаа 15.58%-аар буурч 130.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 8.0 сая төгрөгийн 80 ширхэг үнэт цаас арилжаалагдав

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

9-р сарын 11-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,587.0 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 индекс 16,898.25 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.54% -аар буурсан байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

### Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	80	8,025,010	100,000	102,500	52	17%

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	380.6	
Зах зээлийн үнэлгээ	2,586,973.8	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,898.25	-0.54% ▼
MSE I индекс	8,243.92	0.49% ▲
MSE II индекс	7,353.14	0.37% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Ард санхүүгийн нэгдэл	189,955	199,404,375
Мандал даатгал	886,437	38,097,035
Эрдэнэ ресурс девелопмент корп	34,574	30,092,039
Лэндмн ББСБ	676,784	20,386,428
АПУ	28,597	16,458,501

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Материалимпекс	8,265.00	17.98% ▲
Махимпекс	2,999.00	17.51% ▲
Техник импорт	8,055.00	14.98% ▲
Монгол савхи	550.00	13.90% ▲
Ногоон хөгжил үндэсний нэгдэл	99.00	10.00% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Э-транс ложистикс	130.00	-15.58% ▼
Хишиг уул	580.00	-14.95% ▼
Бэрх уул	440.00	-13.72% ▼
Талх чихэр	13,000.00	-13.27% ▼
Улсын их дэлгүүр	1,259	-13.11% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Ард Секюритиз	229,952,727
Алтан Хоромсог	189,709,800
БиДиСек	136,101,525
Стандарт Инвестмент	35,157,353
Апекс Капитал	32,771,091

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	580.20	617,438.14
Таван толгой	5,860.00	308,618.07
МИК холдинг	12,800.00	265,079.30
Инвекор ББСБ	2,660.00	190,796.26
Говь	200.90	156,724.60

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-НД ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-НД ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НД ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-НД ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.08.06-НД ОЛГОВ
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.07.09-НД ОЛГОВ
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.09.07-НД ОЛГОВ
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.07.30-НД ОЛГОВ
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-НД ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-НД ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.07.08-НД ОЛГОВ
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-НД ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-НД ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.07.31-НД ОЛГОВ
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-НД ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.07.21-НД ОЛГОВ
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



### ОНЦЛОХ МЭДЭЭ

2020 оны 9-р сарын 7-ны өдрөөс 9-р сарын 11-ны өдрийн хооронд “Ард даатгал” /MSE: AIC/ ХК болон “Тэндэм инвэст ББСБ” /MSE: VIK/ ХК шүүхэд нэхэмжлэгч (хариуцагч)-ээр оролцож буй байдалын тухай, “Тэндэм инвэст ББСБ” /MSE: VIK/ ХК 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангаа, “Өндөрхаан” /MSE: ONH/ ХК 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн мэдээллээ Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд байршуулсан байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

### ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

**“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК нь Баян Хөндий Алтны Төслийн эцсийн ТЭЗҮ-ийн эерэг үр дүнг танилцуулав.**

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК (цаашид “Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт орших өөрийн 100% эзэмшлийн өндөр агуулга бүхий олборлох боломжтой Хөндий Алтны Төслийн хараат бус эцсийн Техник Эдийн Засгийн Үндэслэл (“ТЭЗҮ” буюу “BFS”)-ийн үр дүнг танилцуулж байна.

Энэхүү эцсийн ТЭЗҮ-г NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартын дагуу боловсруулсан бөгөөд үүнд: нарийвчилсан уурхайн загварчлал, уулын ажлын хуваарь, боловсруулах үйлдвэрийн анхан шатны инженерийн загварчлал (“FEED”), уурхайн дэд бүтэц, гидрогеологийн үнэлгээ, эрдсийн хаягдлын нэгдсэн байгууламжийн загварчлал, хөрөнгө оруулалт ба үйл ажиллагааны дэлгэрэнгүй зардал, тооцоолол болон эдийн засгийн шинэчилсэн загварчлалыг танилцуулсан.

Эх сурвалж: Эрдэнэ ресурс девелопмент корпораци

**“Тэндэм инвэст ББСБ” /MSE: VIK/ ХК ХК шүүхэд нэхэмжлэгч (хариуцагч)-ээр оролцож буй байдал.**

Компани Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дүгээр тогтоолоор баталсан Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журмын 3.2-д Компаниас тухай бүр нийтэд хүргэх мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна гэж заасны дагуу тус журмын 3.2.2.11-д Компани шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцохтой холбоотой мэдээллийг үүгээр хүргүүлж байна.

Компани 2020 оны 9-р сарын 10-ны өдрийн байдлаар шүүхэд нэхэмжлэгчээр оролцож буй мэдээлэл:

№	ТӨРӨЛ	ТОО	ҮНИЙН ДҮН
1	НЭХЭМЖЛЭЛ	1	38,572,127 ТӨГРӨГ

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

**“Ард даатгал” /MSE: AIC/ ХК шүүхэд нэхэмжлэгч (хариуцагч)-ээр оролцож буй байдал.**

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 443-р тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 3.2-т “Компаниас тухай бүр нийтэд хүргэх мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна” мөн журмын 3.2.2.11-т “Компани шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох”-той холбоотой мэдээлэл гэж заасны дагуу зохих мэдээллийг танилцуулж байна.

“Ард даатгал” /MSE: AIC/ ХК нь 2020 оны 9-р сарын 7-ны өдрийн байдлаар дараах шүүхийн маргаанд нэхэмжлэгчээр оролцож байна. Үүнд:

№	ХАРИУЦАГЧИЙН НЭР	ҮНИЙН ДҮН	ХЭРГИЙН ЯВЦ
1	Э Э П ХХК	68,436,610 ТӨГРӨГ	ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ
2	МИАТ ТӨХК	ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ШИЙДВЭРИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГУУЛАХ	НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ

“Ард даатгал” /MSE: AIC/ ХК нь 2020 оны 9-р сарын 7-ний өдрийн байдлаар дараах шүүхийн маргаанд хариуцагчаар оролцож байна. Үүнд:

№	ХАРИУЦАГЧИЙН НЭР	ҮНИЙН ДҮН	ХЭРГИЙН ЯВЦ
1	Ш У Б Х ХХК*	1,250,000,000 ТӨГРӨГ	ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ
2	Л.НЯМААСҮРЭН	5,000,000 ТӨГРӨГ	ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ

\*Ш У Б Х ХХК-ийн гүйцэтгэгч Ү ХХК нь “Ард даатгал” ХК-д даатгалын хураамжийг төлөөгүй нь гурван шатны шүүхээр тогтоогдсон болно. Нэгэнт даатгалын хураамжийг төлөөгүй этгээдийн учруулсан гэх хохирлыг даатгагч нь даатгалын нөөц сангаас барагдуулах боломжгүй юм.

Дээрх маргаанууд нь шүүхийн шатанд хянан хэлэлцэгдэж байгаа буюу шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй болно.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

## ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

### ОНЦЛОХ МЭДЭЭ

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн III улирлын ээлжит хуралдаан Санхүүгийн зохицуулах хороонд 2020 оны 9-р сарын 8-ны өдөр болж дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

- Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл, тооцоо судалгаа;
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон Төв банкны арилжааны нэгдсэн системийг нэвтрүүлэх ажлын хэрэгжилт;
- Зээлжих зэрэглэлийн талаар;
- Засгийн газрын дотоод үнэт цаас гаргах талаар;
- “Сэндбокс зохицуулалтын орчин журам”-ын төсөл;
- “Санхүүгийн хүртээмжийг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн төслийн тухай тус тус хэлэлцэв.

СТБЗ-ийн ээлжит хуралдааныг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан даргалж, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирал Х.Бум-эрдэнэ болон бусад холбогдох албан тушаалтнууд оролцлоо.

Эх сурвалж: Монголбанк

### МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 2020 оны 2-р улирлын байдлаар нийт 44.0 мянган аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-ын 676.4 мянган ажиллагчид хамрагдсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэл (НДШ) төлж буй ААНБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 2.1 (5.0%) мянгаар, өмнөх улирлаас 1.8 (4.3%) мянгаар, ажиллагчид өмнөх оны мөн үеэс 417 (0.1%)-гоор, өмнөх улирлаас 15.0 (2.3%) мянгаар тус тус өсжээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд хамрагдсан нийт даатгуулагчдын 100.4 (14.8%) мянга нь боловсролын салбарын, 84.6 (12.5%) мянга нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар

үйлчилгээний салбарын, 76.4 (11.3%) мянга нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарын, 69.2 (10.2%) мянга нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарын, 48.5 (7.2%) мянга нь барилгын салбарын, 43.3 (6.4%) мянга нь хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын, 39.3 (5.8%) мянга нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарын, 39.0 (5.8%) мянга нь уул, уурхай олборлолтын салбарын, 27.8 (4.1%) мянга нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын, 147.9 (21.9%) мянга нь бусад салбарынх байна.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

### ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монгол Улс 2020 оны эхний 8 сард нийт 139 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 7.9 тэрбум америк доллар, үүнээс экспорт 4.5 тэрбум америк доллар, импорт 3.5 тэрбум америк доллар боллоо. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.5 (16.3%) тэрбум америк доллар, үүнээс экспорт 908.2 (16.9%) сая америк доллароор, импорт 638.0 (15.6%) сая америк доллароор тус тус буурчээ.

2020 оны 8-р сард экспорт 690.2 сая америк доллар, импорт

511.2 сая америк доллар болж, өмнөх сараас экспорт 270.3 (28.1%) сая америк доллароор буурч, импорт 29.3 (6.1%) сая америк доллароор өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2019 оны эхний 8 сард 1.3 тэрбум америк долларын ашигтай гарч байсан бол 2020 оны эхний 8 сард өмнөх оны мөн үеэс 270.2 сая америк доллароор буурч, 1.0 тэрбум америк долларын ашигтай байна.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

### МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.